

**Хорезмын Шахын эсрэг хийсэн  
аян дайн**

*Доктор, профессор Удо Б. Баркманн  
/ХБНГУ, МУИС-ийн зочин профессор/*

Шах Мухаммад Ала ад-Дин (1200-1220 оны хооронд засгийн эрхийг барьж байв)-ы Хорезмын хүчирхэг улс Дорнод Туркестаны баруунтаах уудам нутгийг хамран оршиж байлаа. Шах Мухаммадын улс умар зүгт Арап тэнгистэй, өмнө тийш Персийн булан, зүүн зүгт Памирийн нуруу, баруун тийш Цагросын нуруутай хаяа нийлж, Дундад Ази, Афганистаны ихэнхи хэсэг, Персийг бүхэлд нь хамарч байв. Суурьшмал иранчууд, нүүдэлчин түрэг угсааны иргэд тус улсын хүн амын үндсэн хэсгийг бүрэлдүүлж байлаа. Эдгээр угсаатны аль нэг нь зонхилж, төр барих тухай бүрдээ энэ уудам нутагт угсаатан бүрэлдэх үйл явцад өөр өөрийн нөлөөг хүчтэй үзүүлдэг байв. XI зууны үеэс эхлэн сельджукийн ноёд төр барих болсноор түрэгчлэх үйл явц давамгайлж байв.

Шах Мухаммад Ала ад-Диныг нэгэн хүчтэй лидер гарч ирлээ гэж улс даяар бодож байв. Гэвч Шах Мухаммад өөрийн гэсэн эрмэлзэлтэй байсан ч хатан эх Тэркэний хүчтэй нөлөөн дор байсан. Ан-Насавид дурдсанаар Шах хэзээ ч ямар нэгэн байдлаар ээжийнхээ үгнээс зөрж байсангүй, "их ч бай бага ч бай, чухал ч бай, чухал биш ч бай бүхий л хэрэгт тэрээр ийм байх агаад бөгөөд үүнд хоёр шалтгаантай байлаа. Нэгдүгээрт: түүнд ээжийнх нь олгосон хүмүүжлийн дагуу элгэн садны эв найрыг сахих, хоёрдугаарт: улсын эмирын олонхи нь түүний удам угсааны хүмүүс байсан явдал юм."<sup>1</sup> Иймээс Тэркэн хатан хүүгийнхээ төр гүрний хэрэгт хүчтэй оролцож, тоо тоомшгүй олон далд явууллагыг зохион байгуулахын сацуу дээд албаны түшмэд нарт шууд зарлиг буулгаж, улсын менгэ сангийн хэргийг захиран, өндөр алба татвар ноогдуулж, дарамт шахалт үзүүлсний улмаас олон олон газраас гомдоллох явдал нэмэгдсээр байлаа. Хатан эхийнхээ дэмжлэг нөлөөгүй бол Шахын бодлого дотроо тун их зөрчилтэй байв. Язгууртан ноёд өөрт нь үнэнчээр зүтгэж байгаа эсэхэд Шах эргэлзэж байсан тул нутгийн хэсэг ноёдын эрх мэдлийг нь хураан авснаар өөрийнхөө эсрэг хандсан хүчийг бий болгожээ. Хорезмын Шах сөрөг хүчин болох тэдгээр хэсэг феодал язгууртан ноёдтой тэмцэх тэмцлээ доорхи хоёр зүйлд түшиглэж байсан нь нэгдүгээрт, төвлөрсөн хүчинг байгуулах сонирхолтой иргэний засаг захиргаанд хоёрдугаарт, нүүдэлчин түрэг угсааны цэрэг. Түүний захирагч ноёдод нь эзэмшил газар (түрэг хэлээр:ikta) өгөх замаар алба хаалгадаг байжээ.

Шах Мухаммад өөрийгөө лалын ертэнцийн дорно хэсгийн дээд эзэн хэмээн үзэх болсон учраас лалын султан гэж дуудуулах болжээ. Энэ алдрыг авч явна гэдэг бол лалын шашныг хамгаалах, шаардлагатай газарт лалын шүтлэгтнүүдийг бус шүтлэгтнүүдийн ноёрхлоос чөлөөлөх үүргийг давхар хүлээх эрхийн үндэслэлтэй болж байна гэсэн үг байлаа. Султан гэсэн алдрыг ёсоор нь авахын тулд "бурхны газар дээрхи орлогч", "бурхны элчийн орлогч" хэмээгдэж, лалын их гүрний тэргүүнд тооцогдох Багдадын халифаар султанд өргөмжлүүлэх хэрэгтэй байв. Гэвч түүнийг ийнхүү өргөмжлэх нь Халиф ан-Насир Ибн ал-Мустади /1180-иас 1225 оны хооронд Халиф байсан/-гийн улс төрийн тооцоонд ороогүй байсан юм. Тэрээр "Халифийн улсдаа тухайн үеийн боломжийн хирээр тодорхой хүчин чадлыг олох" арга замыг эрэлхийлж байлаа. "Тэрээр өөрийн цэрэгтэй мөн дипломат харилцаатай байв. Ялангуяа бүх "лалын санваартнууд" /лалын санваартан хүн гэр бүлтэй байх тул энэ нь лалын санваартнууд гэр бүлийнхээ хамт гэсэн үг юм/-ыг Халифын улсаа тойруулан цуглуулахыг тэрээр тун их чармайж байсан... Тэрээр шүүгч, номлогч нарын сонгуульд оролцож, шашны онолын

<sup>1</sup> З. М. Бунийтов, Государство Хорезмшахмаков-Ануштегинидов (1097-1231), Москва 1986, тал-128.

мэдлэгтэй хүн гэж хүлээн зөвшөөрөгдхийг чармайж байлаа.<sup>2</sup> Тэрээр бодлого явуулсныхаа үрээр уlam олон язгууртан ноёдыг өөрийн талдаа татаж чадсан юм. Халиф түүнийг хүлээн зөвшөөрөхгүй байсан явдал Шах Мухаммадыг тун хилэгнүүлж, Халифын эсрэг дайн хийхээр шийдэхэд хүргэсэн. Гэвч түүний энэ хэт түргэдсэн, бодлогогүй шийдвэр лалын ихэнхи санваартан нарыг өөрийн эсрэг хандуулсан бөгөөд лалын сургаал номлогч Мажид ад-Дин Багдадыг түүний тушаалаар хөнөөсөн гэх мэтийн бусад хэргүүд лалын санваартан нар болон түүний хооронд үүссэн хагаралыг уlam гүнзгийрүүлсэн юм. Үүний уршиг нь хожим илэрч, Мухаммад монголчуудын довтолгооноос өөрийгөө хамгаалах үе болоход тэрээр монголчуудын эсрэг “ариун дайн”-ыг хийх чадалгүй болсон байлаа. Гэсэн хэдий ч тэрээр дайн хийж, өөрөө өөртөө хүлээлгэсэн лалын Султаны үүргийг биелүүлэхийг оролджээ. Түүний улсын зүүн талд Дорнод Туркестанд байрлах Хар Китай улсын эсрэг 1207 онд аян дайныг хийхийн тулд тэрээр Хотан, Самарканд, Бухарт өrnөсөн лалын шашинтан нарын бослогыг ашиглажээ. Гэвч уг аян дайн амжилттай болж чадсангүй. 1210 онд Шах Мухаммад цэргээ Хар Китайн эсрэг дахин давшуулсан. Тэрээр Хар Китайн их цэргийг цохиж чадсан боловч эцсийн ялалтыг авч чадсангүй. Ялалт байгуулсныхаа дараа Мухаммад өөртөө шинэ алдар хүртээж, Сельджукийн сүүлчийн хан Шангарын /1118-1157/ нэрээр заримдаа бүр Искэндэр /Александр, Македонийн “Александр”/-ийн нэрээр нэрлэх болжээ. Сайхан өнгө үзэмж, нэр алдраар өөрийгөө чимэгч Хорезмын Шахын хувийн зан чанар нь түүний эрх мэдэлтэй ер таарч тэнцэхгүй байв. Эрхшээлдээ оруулсан орнууддаа цэргээ засаж, хүн ардыг нь цэргүүдийн дарамтлааас хамгаалах чадвар түүнд огт үгүй байлаа.” Дээр дурдсанчилан Арслан зэрэг лалын ноёд монголчуудад дагаар орсон зэрэг үүнтэй төстэй явдлууд лалын ертөнцөд түүний нэр хүнд унасаар байсныг батлах мэт.

Хар Китай улсад Найманы Хүчүлүг хантай нягт холбогдол бүхий өөрчлөлтүүд гарсан. Бид эргэн санацааяа. Найман ялагдал хүлээсний дараа Хүчүлүг хан, Мэргидийн Тогтоа Бэхи нар Тэмүжиний эсрэг хамтран тэмцэхийн тулд 1206 онд Эрчис мөрний эрэг дээр их цэргээ нэгтгэсэн. Гэвч монголчууд цэргийг бут цохисон тул Хүчүлүг хан Хар Китай улс уруу зугатан одсон. Тэнд тэрээр тун богино хугацааны дотор Гүр хааны итгэлийг олж чадсан гэдэг. 1210 онд Мухаммад Хар Китайг довтлох үед Хар Китайн хаан Хий-лү-ку /1178-1213 онд төр барьж байсан/ ойр тойрны хэрмэл нүүдэллэмэл ардыг бүгдийг цуглуулж цэрэг байгуулах тушаалыг Хүчүлүгт өгчээ. Хүчүлүг үүнийг биелүүлсэн боловч үүгээр сэтгэл нь ханасанүй. 1211 онд тэрээр Хий-лү-ку-г барьж, өөрийн биеийг “Хaan эцэг” /тэрээр Хий-лү-ку-г ийн нэрлэдэг байжээ./-ийнхээ захирагчаар томилсон байна. Гүр хаан болон түүний Мухаммадад өгөхийг амласан охиныг гаргаж өгөхийг Хүчүлүгээс Мухаммад шаардсан боловч Хүчүлүг татгалзсан. Харин Хүчүлүг тэр охиныг өөртэйгээ гэрлүүлэхийг шахаж шаардаж байв. 1213 онд Гүр хаан нас бармагц Хүчүлүг өөрийгөө Хар Китайн хаан ширээнд залжээ. Ийнхүү бүрэн дүүрэн эрх мэдлээр хангагдсан Хүчүлүг илүү бие даасан байдалтай байх болжээ. Тэрээр хуучин Хар Китайн газрыг эгүүлэн өгөхийг Шахаас шаардсанд Шах уг асуудлыг хэлэлцүүлэхээр өөрийн элч Эмир Мухаммад Ибн Кара-Касимаг илгээсэн боловч Хүчүлүг элчийг барьж хорьсон байна. Ийнхүү Хүчүлүг Шахыг ихэд гомдоосон нь тухайн үед Шах гадны ямар ч дайралтыг сэрг чадахааргүй байгааг тэрээр бас тооцоолсон хэрэг юм. Несторианы шашинтан гэгдэх Хүчүлүг эхнэрийнхээ нөлөөгөөр буддийн шашинд орсноор лалын шашныг хялан хавчих арга хэмжээг ихэд явуулж байв. Тэрээр өөрийн улс дахь лалын шашинтан нарыг Хар Китай нарын өмсдөг хувцас өмсөхийг шаардаж, лалын шашны үйлийг хориглосны хамт сайтар тунгаан бодсоны эцэст цэрэг эрсээ лалын шашинт айл өрхүүдэд тараан байрлуулжээ. Хүчүлүг хийж буй үйл ажиллагааныхаа цаад үр дагаврыг харах чадвар байгаагүй шиг санагдаж байна. Тэрээр 3000 орчим лалын санваартанг баривчилж, алдарт Имам, Шейх Ала ад-Дин Мухаммад ал-Хотаниг цаазаар авсан байна.

<sup>2</sup> Cf. C. Cahen, Der Islam, Vom Ursprung bis zu den Anfaengen des Osmanenreiches, (=Fischers Weltgeschichte, Bd. 14) I, Frankfurt a. M. 1968.

Эдгээр нүгэлт хэрэг нь лалын Султаны зүгээс хариугаа хүртэх ёстой байсан боловч тиймэрхүү зүйл тохиолдоогүй юм.

Гагцхүү Чингис хаан л өөрийн хэээний дайсан Хүчүлүгийг мартсангүй. Хүчүлүгийг устгаж, түүний улсыг дайлах тушаалыг 1216 онд Чингис өөрийн жанжин Зэвд өгсөн байна. Зэв цэргээ дагуулан, 1217 онд Хар Китай улсын нутгийн гүнд дайран орсон. Нэг л базаахгүй зүйл болох гэж буйг мэдсэн Хүчүлүг түргэхэн зугатсан бөгөөд Монголын шилдэг цэрэг эрс түүнийг нэхэж, 1218 онд Бадахшан орчмын газраас барьж зүйл дуусгажээ. Дорнод Туркестанд баримталсан монголчуудын тактик урьд урьдын байлдааны ажиллагаанаас үндсээрээ ялгарч байсан. Зэв хоёр арван мянгатаа аваад Хар Китай улсад довтлох үедээ "хүн бүр өөр өөрийн итгэл үнэмшлээ хадгалан үлдэж, эцгийнхээ заасан замаар явах хэрэгтэй" гэдгийг хүн ардад нь зарлан тунхаглаж байв. Монголчууд ямар нэгэн байдлаар олз омог хийхээс зайлсхийж байлаа. Ийнхүү энэ нь Чингис, түүний жанжин нар дайсныхаа нөхцөл байдлыг нарийн судалж, сэтгэл зүйн тооцоотойгоор дайтдаг тэр гаралтай чадварыг баталсан юм.

Монголчууд лалын шашныг илтэд харж үзэж байсныг юугаар тайлбарлах вэ? Хэдийгээр монголчууд шашинд ихээхэн хүлээцтэй ханддаг байсан нь батлагдах боловч энэ нь олз олоход монголчуудад хэзээ ч хориг саад болж байсангүй. Дорнод Туркестаны хувьд лалын шашинд хүлээцтэй хандсан нь тун ойлгомжтой зүйл байлаа. Энэ нь Хүчүлүгийн улсын лалын шашинт ард түмэнд аврал найдварын баталгаа болж байсан төдийгүй нөгөө талаас Шахын эсрэг тэмцэхэд монголчууд "тусалж" болзошгүй гэдгийг Хорезмын лалын сөрөг хүчинийхэнд ойлгуулахад чиглэсэн байв.

Чухам энэ үед Чингис хаан Шахын улсыг довтлохоор төлөвлөж байсан гэж үү? Доорхи үйл явдлууд нь түүний ийм санаатай байсныг батлахгүй боловч Чингис маш холын хараатай, нарийн тооцоотой тактич байсан ажээ.

Хорезмын Шах Чингис хаантай холбоо тогтоох санаачилгыг 1215 онд гаргажээ. Шахыг ийм алхам хийхэд хүргэсэн шалтгааныг "Чингис хаан Хятадыг эзлэв гэсэн сураг чимээ Шахад сонсогдоход тэрээр үүний үнэн зөв эсэхийг тогтоолгооэр эрхэмсэг төрсөн Сайд Баха ад-Дин ар-Раци тэргүүтэй төлөөлөгчдийг Хятад уруу илгээсэн"<sup>3</sup> хэмээн Имад ал-Мулк Таж ад-Дин-д бичсэн байдаг. Шахын явуулсан төлөөлөгчид 1215 оны VI сард Бээжинд ирсэн бөгөөд Чингис хаан тэднийг найрсгаар хүлээн авч, бэлэг сэлт өгөөд Шахад илгээлт явуулсан. Уг илгээлтэнд: "Би бол Дорнодыг захирсан эзэн, чи харин Өрнөдийг захирсан эзэн. Бидний хооронд найрамдал, энхийн эвдэршгүй бат гэрээ хэлцэл байгуулагдаж, арилжаа наймаачдыг аялуулж, аян жинг хийлгэтүгэй"<sup>4</sup> хэмээжээ. Чингис 500 тэмээ бүхий жингийн цувааг бэлтгүүлж, алт, мөнгө бусад үнэт зүйлсийг Шахад өгч явуулсан. Тэрээр уг жингийн цувааны худалдаачдад "Сайн хөршийн, энх тайванч, найрамдалт харилцаа тогтоох" зарлиг буулгасан. Чингисийн Шахад дамжуулж хэлсэн: "Чамтай энх тайванч харилцааг хадгалахыг би өөрийн нэг үүрэг гэж үзэж байна. Чи миний хувьд хамгийн хайртай хүү шиг минь билээ. Би Хятад болон түрэг угсааны хөрш орнуудаа эзлэн авч, ард иргэдийг нь хэдийнээ эрхэндээ оруулсан нь чамд нууц биш."<sup>5</sup> Шах Мухаммад ихэд гайхсан бөгөөд уг илгээлт дэх эцэг хүний өршөөнгүй өнгө аяс нь түүнийг гомдоосон. Чингисийг өөрийн талдаа татахыг эрэлхийлж байсан Мухаммад Чингисийн элчид "Би ямар эд хөрөнгөтэйг, миний эд хөрөнгө хир их болохыг харин чи мэдэх үү? Намайг хүү минь гээд байгаа энэ солиотой амьтан хэн юм бэ?"<sup>6</sup> гэж хэлсэн гэдэг.

Жингийн цуваа буцаж ирсний хойно Чингис дахин шинэ жингийн цувааг бэлтгэж, Омар Хожой ал-Оттари, ал-Жамал ал-Мараги болон Фаҳр ад-Дин ад-Дицаки ал-Бухари зэрэг алс нутагт аялаж дадсан худалдаачдаар ахлуулсан ажээ. Энэхүү жингийн цуваанд

<sup>3</sup> З. М. Буниятов, Государство Хорезмшахмаков-Ануштегинидов (1097-1231), Москва 1986, тал-132.

<sup>4</sup> З. М. Буниятов, Жизнеописание Султана Жалал ад-Дина Манкубурни. Баку. 1973, тал-78.

<sup>5</sup> Мөн тэнд. тал-78.

<sup>6</sup> Мөн тэнд. Тал-78.

нийт 450 лалын худалдаачин, монголын 100 орчим дагалдагсад явж байлаа. Тэдний зарим нь Чингисээс алтан, мөнгөн пайз гардаж авсан байх агаад энэ нь Шахын нутагт худалдаа арилжаа хийж, тэр нутгийн үнэтэй, ховор барааг худалдан авахын тулд. Шахын нутагт нэвтрэн орох эрхийг олгох зориулалтай байжээ.

1218 оны сүүлчээр Зүйийн цэрэг Шахын 60 мянган цэрэгтэй нүүр тулсан. Ийм тохиолдолд Шахтай дайн тулааны ажиллагааг хийж болохгүй гэсэн тушаалыг Зүйи Хаан эцгээсээ авсан байв. Шах цэргээ тулалдааны бэлэн байдалд оруулах үед Зүйи түүнд бичиг илгээж, Монголын Хааны хоригийг түүнд мэдэгджээ.<sup>7</sup> Гэвч Мухаммад тулалдаанд дуудаж байлаа. “Надтай дайн бүү хий гэж Чингис хаан чамд тушаасан бол харин надад бүхнээс хүчтэй Аллах чамтай дайтахыг тушааж, надад аз хийморийг зөгнөж байна. Гүр хаан, Хүчүүлүг хан болон чиний хооронд надад ямар ч ялгаа байхгүй, учир нь та нар онголон тахих ёсонд бүгд ижил юм.”<sup>8</sup> Энэ хариулт дайн зарласантай утга нэг байлаа. Гэвч монголчууд тулалдаанд ялсан бөгөөд Шах 20 мянган цэргээ алдсан юм. Хэдий тийм боловч Чингис Шахын эсрэг дайныг эхлүүлэх явдлыг алгуурлаж байлаа.

1218 оны сүүлчээр Чингисийн илгээсэн худалдаачдын жингийн цуваа Шахын гүрний Отрап хотноо хүрч ирсэн. Тэнд уршиг зовлон хойноосоо дагуулсан гэнэтийн явдал тохиолдсон. Тэркэн хатны садангийн хүн болох хотын дарга Инал хан худалдаачид болон монголын дагалдагсдыг тагнуул туршуул хэмээн буруушааж, цаазлаад, тэдний авч явсан бэлэг сэлт, бараа таваарыг өөртөө авчээ. Эл үйл явдалд түүхийн ном сударт ч тэр, он дарааллын бичигт ч тэр олонтаа тайлбар өгсөн байдаг. Энэ талаархи Инал ханы бодол сэдэл, Шахын байр байдлын талаар хэзээ ч нэг мөр болгон тайлаагүй байна. Хэрвээ Чингис Шахын эсрэг дайн зарлахын тулд өөрт ашигтай байх дайныг хийлгүйгээр орхисон бол харин энэ өдөөн хатгалгад зайлшгүй хариу шийтгэлийг өгөх ёстой болсон, учир нь эл өдөөн хатгалга монгол эзний нэр хүнд, нэр төрөө дээдлэх үзлийг нэн ихээр хөндсөн байжээ. Гэсэн хэдий ч Чингис асуудлыг өөрийгөө хүндэтгэн зэвсэг хэрэглэлгүйгээр шийдвэрлэхийг оролдсон. Тэрээр Шахад “Чи худалдаачдын аюулгүй байдлыг хангаж, тэдний хэнийг нь ч барихгүй хэмээн гарын үсгээ зурж, миний өмнө үүрэг хүлээсэн билээ. Гэвч чи үнэнч бусаар хандаж, үгнээсээ буцлаа. Үнэнч бус байх нь шившигтэй юм, тэр ялангуяа лалын Султаны хувьд бүр ч шившигтэй юм. Хэрвээ Инал ханы үйлдэл чиний тушаалын дагуу биш байсан гэдгийг нотолж байх аваас түүнийг хийсэн хэргийнх нь төлөө шийтгэж, улмаар цус урсахаас сэргийлж, олон түмний уур хилэнг намжаахын тулд Инал ханыг надад авчирч тушаа. Эс бөгөөс дайн болно...”<sup>9</sup> гэж тэрээр Шахад хэлүүлжээ. Чингис хааны тавьсан шаардлагыг биелүүлж, Иналыг өгөхөөс Шах татгалзаж, монголын элчийг цаазаар авах тушаалыг тэрээр өгсөн гэсэн нь Мухаммадтай дайтахаас өөр боломжийг Чингис хаанд олгосонгүй. Чингис Их Хурилдайг зарлан хуралдуулж, алтан ургийнхан болон цэргийн дээд жанжин нартайгаа энэ удаагийн дайны төлөвлөгөөг зөвлөлдсөн. Мөн тэр үед хаан ширээг хэн залгамжлах вэ гэдгийг тэрээр шийдсэн байна. Монголын Нууц Товчоонд бичсэнээр Чингисийн хатан Есүй түүнийг дайнд мордохоосоо урьдаар хаан ширээний залгамжлалын асуудлыг шийдэхийг сануулсан. Есүй хатан хэлсэн нь: “өндөр даваа даван өргөн мөрөн гэтлэн урт цуур цуураа олон улсаа зөвшөөрөн сэтгэв. Төрсөн эх амьтанд мөнх үгүй ажгуу. Хүлгүүд хөвгүүдийнхээ хэнийг нь хэмээму.”<sup>10</sup> Үүнийг шийдэх нь Чингист мэдээж хялбар бус байсан. “Монголчууд хаан ширээг гэр бүлийн хүрээнд удам дамжуулан залгамжлах уламжлалгүй. Нуудэлчдийн ойлголтоор улс (өргөн утгаар гүрэн гэсэн үг /Зохиогч/) гэдэг бол бүхэл бүтэн овгийн эзэмшил юм. Энэ ойлголтын үүднээс нас барсан хааны авга юм уу, ах, дүү нь тэр овгийн ахмад нь болохын хувьд хаан ширээ залгамжилах боломжтой

<sup>7</sup> Рашид ад-Дин. Сборник летописей. Том I. Книга вторая. Москва, Ленинград. 1952. тал-190.

<sup>8</sup> З. М. Бунятов, Жизнеописание Султана Жалал ад-Дина Манкбурни. Баку. 1973, тал-53.

<sup>9</sup> Мөн тэнд. Тал-79-80.

<sup>10</sup> Index to the Secret History of the Mongols, by Igor de Rachewiltz, (= Uralic and Altaic Series, Vol. 121), Bloomington 1972, 10231-10303.

байжээ... Ууган хүү айлын тэргүүн тул өв залгамжлах эрхээ эдлэх хүсэлт тавихад харин отгон хүү эцгийн голомтыг өвлөн захирагч болохын хувьд мён тийм эрхийг эдлэх боломжтой байв.<sup>11</sup> Монголын Нууц Товчоонд бичсэнчлэн Чингисийн алтан ургийнхны хүрээнд л өв залгамжлах тухай асуудал яригдсан байна. Монголын Нууц Товчоон дахь дүрслэл хөвгүүдийн зан чанарын талаар төсөөлөх боломжийг олгож байна. Чингис эхлээд хүү Зүчийг үгээ хэл гэсэнд Цагаадай түүнээс урьдаж хэлсэн нь: "Зүчийн хэллээ хэмээрүүн. Зүчийг юу түшин өгүүлмүй. Энэ мэргэдийн цул улзуураа хэр мэдүүлхүүн бид."<sup>12</sup> "Өгөдэй өр зөөлөн буй. Өгөдэйг хэмээлдье. /өргөмжилье/ Өгөдэй хан эцгийн дэргэд ажуу. Бараа их малгайн буулиа таниулбаас болно зэ."<sup>13</sup> Цагаадай ийм санал дэвшүүлснээрээ отгон хүү Толуйг асуудлын гадуур орхисон мэт санагдаж байна. Цагаадайн хувьд хаан ширээ залгамжлах талаар ярилтгүй бөгөөд Өгөөдэй тайван, төв цэгц байдлаараа ирээдүйд улс гэрийг хэнээс ч илүүтэйгээр удирдаж, нөлөөлж чадна гэж Цагаадай магадгүй итгэсний байлаа. Чингис энэ саналыг зөвшеөрсөн боловч Зучи, Цагаадай хоёрын таарамжгүй байдал түүний сэтгэлийг зовоож байлаа. Тэрээр Чингисийн алтан ургийн эв нэгдэлд аюул тулгарч болзошгүйг мэдэж, сануулж хэлсэн нь: "Зучи, Цагадай хоёр угстээ хүрэлцгэгүн. Иргэнд бүү инээлгэгүн. /Инээдэм бологтун/ Ардад бүү ахаруулагтун. Эрт Алтан Хучир хоёр энэ мэт үг барилдаж жич үгэндээ үл хүрэхийн тул хэр хийгдлээ."<sup>14</sup>

Өөрийн биеийг нь сонгосон тухай тэр саналыг Өгөөдэй даруухан хүлээж аваад түүний хэлсэн нь "Хаан эцэг соёрхож өгүүл хэмээгдвээс юугаа өгүүлэх /яхин өгүүлэх/ чадахаар хатуужсугай."<sup>15</sup>

Хорезмын Шахын эсрэг дайн эхэлсэн. Монголын цэрэг их ав хомрого хийж, хоол хүнсээ базааж аваад 1219 онд Шах Мухаммадын улсын нутагт дайран орсон. Шахын 400 мяанган байлдагч бүхий хүчтэй цэрэгтэй дайтахад хүчиний тэнцвэрийг бий болгохын тулд Чингис бүх хүчээ дайчилахын хамт харьяат холбоотнууддаа дайнд хамтрах зарлиг гаргаж байлаа. Тангадын хаан Бурханд мён Чингис хааны ийм зарлигийг дамжуулсан боловч тэрээр үүнийг хүлээн авахаас татгалжээ. "Хүч ядан бөгөөтөл хан болтол юун хэмээж цэрэг үл нэмэн их үг өгүүлж илгээжээ."<sup>16</sup> гэж Бурхан хэлсэн хэмээн түүний итгэлт нөхөр ярьсан нь Чингисийн сонорт хүрсэн.

Чингис хааны цэрэг Памирын нурууны Алайн давааг даваад Шахын нутагт цөмрөн орсны хойно эсрэг талынхаа нутгийн гүнд нэвтэрч тэнд дайралтанд орох үедээ дахин нэгдэхээр болж, довтолгооны үндсэн хэд хэдэн чиглэлд хуваагдсан. Зэв, Сүвээдэй баатар, Тогачар нарын толгойн сэргийлэхийн анги магнайд нь явж байлаа. Чингис тэдэнд тушаасан нь: "Хадуун одож Султаны цаана гарч биднийг хүргүүлэн хамсагтун хэмээн илгээв."<sup>17</sup> Гол замын цэрэг ч мён давшилтын тодорхой чиглэлийг авсан байлаа. Цагаадай, Өгөөдэй Отрар хотыг бүсэлж, Зучи Сырдарьяя мөрний адаг орчмын хотуудыг, Алаг ноён Сырдарьяя мөрний эх орчмын хотуудыг дайрахаар болжээ. Чингис хаан, Толуй нар цэргийн гол хүчийг захирч байв.

Аян дайн эхлэхэд монголчууд тоогоор хол илүү, дайны болон цэргийн зохион байгуулалтын хувьд авчин их туршлагатай, хүчирхэг дайсантай тулгарсан байлаа. Шахын цэрэг сайн дасгалжсан, сайн зэвсэглэсэн цэрэгт зүй ёсоор ордог байлаа. Түүний цэргийн гол цөмийг нүүдэлчин түрэг угсаатнууд бүрдүүлж байв. Шах Мухаммадын өмнөх хаадын бий болгосон тогтолцоо хүн амьг цэргийн хэрэгт сэнхруулж, улмаар дайны үед олон тооны цэрэг эрсийг дайчилж чадах гол нөхцөл болж байжээ. Он дарааллын бичигт тэмдэглэгдсэн жишээнүүд үүнийг тодорхой харуулж байна: Хорезмын Шах Ала ад-Дин

<sup>11</sup> P. Ratchnevsky, Genghis Khan, His Life and Legacy, Oxford 1991, S. 125.

<sup>12</sup> Index to the Secret History of the Mongols, by Igor de Rachewiltz, (= Uralic and Altaic Series, Vol. 121), Bloomington 1972, 10310-10312.

<sup>13</sup> Мён тэнд 10422-10424.

<sup>14</sup> Мён тэнд 10430-10433.

<sup>15</sup> Мён тэнд 10502-10503.

<sup>16</sup> Мён тэнд 10526-10527.

<sup>17</sup> Мён тэнд 10603-10604.

Мухаммад төрийн эрхийг авсны дараах хэдхэн хоногийн дотор 70.000 морьтон цэргийг цуглувалж чадсан байна. 1218 онд тэрээр цэргийн парад /үзүүлэх тогтолц/ зохион байгуулахад түүнд 150.000 морьт цэрэг, 100.000 явган цэрэг оролцсон байна. Хар Китай (1211/1212) болон Багдадын Халифтай дайтахад тэрээр бүр 400.000 цэргийг дайчилж чадсан байна. Буниятовын бичсэнээр Монголчууд довтлохын урд өдөр Туркестан, Мавара ан-Нахр-д 400.000 морьт цэрэг, Отарт 20.000 цэрэг, Бенакет-д 10.000 цэрэг, Самарканад 110.000 цэрэг Шахын мэдэлд байжээ. Мөн үүн дээр Балх, Женд, Хуттулян, Кундуц, Жаркенд гэх мэт газруудад байрлуулсан цэрэг нэмэгдэж ирнэ. Зөвхөн мамлюкуудаас бүрдсэн 10.000 хүнтэй хүчирхэг тортон цэрэг Шахыг шууд дагалдан, биөийг нь хамгаалж байв. Сурвалж бичгүүдээс Буниятовын түүж цуглувалсан тоо баримтуудаас үзэхэд дор хаяж 540.000 цэрэг бүхий Шахтай Чингис хаан тулгарсан байна. Тэд илд, жад, шийдэм, нум, сум, бэхлэлтийг эвдэх хэрэгслүүд, довтолгооны цамхаг, хана нураагч, хэрэм өөд авирах шат зэргээр зэвсэглэсэн байлаа. Хамгийн дээд албан тушаалтан болох Сахибын удирдлаган дор ажиллах цэргийн жанжин Диван ал-Ард гэдэг цэрэг удирдах газар Шахын цэргийг захирч байжээ. Цэргийн хянан шалгагч /Назир а-Жайх/, улсын хамгийн сайн эмирүүдийн дундаас нэгэн жанжин болон бүхий л шатны жанжин нар цэргийн үйл ажиллагаанд санаа тавьдаг. Цайз бэхлэлт гэдэг бол тэдний батлан хамгаалах үзэл баримтлалд гойд чухал үүрэг гүйцэтгэдэг учраас Хорезмын шах нар цайз бэхлэлт барихад онцгой анхаарал тавьдаг байв. Тэдний барьсан зарим цайз бэхлэлт нэвтрэхийн аргагүй бат бэх байсныг түүхийн хуудаснаа шагшин магтсаар ирсэн билээ.

Чингис аян дайн хийхийн өмнө өөрийн дайснаа урьдын адил ул суурьтайгаар судалдаг байв. Монголын туршуулууд дайсныхаа нутгаар энд тэндгүй хэрэн тэнэдэг байжээ. Шахын цэрэг янз бүрийн угсаатнуудаас бүрдсэнтэй холбогдон гарах хагаралтай байдлыг тэд онцгой анхааран ажиж байв. Янз бүрийн овог угсаатнуудын хоорондын хагарал, тэмцлийн улмаас тэдний зарим нь монголчуудыг довтлох үед Чингисийн талд орж магадгүй гэж бодоход хүргэж байлаа. Энэ нь нэгэн чухал шинэхэн тактик болж байв. Чингис байлдан дагууллынхаа эхэн үеэс л дайсагнагч талынхаа зохион байгуулалттай хүчийг сарниулахын тулд тэднийг хооронд нь хагаралдуулахад чиглэсэн бодлогыг явуулж байлаа. Чингис тэр байтугай Тэркэн хатны байр суурийг саармагжуулах оролдлогыг хийж байв. Тэрээр Тэркэн хатанд нэгэн илгээлт явуулж, түүнд доорхи саналыг тавьсан: "Хүү чинь чиний эрхэд ямар хайр гамгүй хандаж байсныг чи мэдэж байгаа. Одоо би эмирүүдийн заримтай нь хэлэлцэж тохироод хүүгийн чинь эсрэг дайнд мордох гэж байгаа бөгөөд гэхдээ би чиний эзэмшил газарт довтлохгүй. Хэрвээ чи миний энэ саналыг хүлээн авах бөгөөс нааш нь хүн явуулаарай, тэр чамд (миний үгэнд итгэж байгааг чинь) нотлох бөгөөд дараа нь бид Хорезм, Хорасан, мөн Жейхун /Амударъя/ мөрний цаад эргийн газрыг чамд шилжүүлж өгье."<sup>18</sup> Шахын эмирүүд монголчуудтай нууц хуйвалдаан хийж байна гэсэн сэжиг төрүүлэхүйц хуурамч захиануудыг мөн тухайн үед Чингис хаан Шахын гарти оруулж чадсан. Шахын сэтгэхүй, түүний барагтай хүнд итгэдэггүй занг Чингис сайтар мэдсэн юм шиг санагдаж байна. Тэр буруу тооцоолсонгүй. Шах дайны асуудлыг хэлэлцэх зөвлөлийг хуралдуулж, монголчуудын довтолгоог хэрхэн сөрөх талаар жанжин, одон орон судлаач нартай хэлэлцэх үед тэд улсын бүх цэргийг Сырдарьяа мөрний эрэг дээр цуглувалж, улмаар тэнд замдаа эцэж ядарсан монголчуудад цохилт өгье гэсэн саналыг тавьсан боловч Шах өөрийн итгэлт хүмүүсийн зөв зүйтэй саналыг хүлээн авахаас татгалзсан. "Мухаммад өөрийн цэргийн жанжин нар, засаг ноёддоо үл итгэсэн тэр чигээрээ дайныг явуулсан юм. Шах задгай тал газар цэргийн олныг ашиглаж дайтахын оронд цэргүүдээ хэсэг хэсэг болгож, хотуудад тараан байрлуулсан..."<sup>19</sup> гэж Рачневский бичсэн байдал. Шахын шийдвэр маш том алдаа болсон агаад тухайн үедээ ч нэн их шүүмжлэгдсэн гэдэг. Шахын цэргийн дийлэнхи хэсэг нь морин цэрэг байсан бөгөөд морин цэрэг гэдэг бол зөвхөн уудам орон

<sup>18</sup> З. М. Буниятов, Жизнеописание Султана Жалал ад-Дина Манкубурни. Баку. 1973, тал-82.

<sup>19</sup> P. Ratchnevsky, Genghis Khan, His Life and Legacy, Oxford 1991, тал-192.

зайд л сайн тулалдаж чаддаг гэдгээс үзэхэд Шахын цэргийн тооцоо алдаатай байсан нь тодорхой байна. Тэрээр ийм шийдвэр гаргаснаараа нүүдэлчин түрэг угсааны цэргүүдийнхээ байлдааны гаршиж дадсан, шалгарсан арга барилаас татгалзсан хэрэг байлаа. Түүх бичигт тэмдэглэн үлдээнээс дүгнэхэд уг байлдааны арга барил нь монголчуудынхтай тун төстэй байсан бөгөөд энэ нь толгойн сэргийлэх анги, баруун, зүүн жигүүрээс бүрдэх ба баруун, зүүн жигүүр нь цохилт өгөх гол цөм үрүү нэг шугамаар давшихын зэрэгцээ арын сэргийлэх анги, нуувчны анги зэргээр хамгаалуулж байдаг байна.

Хааныг нь гомдоосны улмаас гэмт этгээдийг газар дээр нь шийтгэхийн тулд 1219 оны IX сард монголчууд Оттарын зүг хөдөлсөн. Оттарын оршин суугчдад тэднийг юу хүлээж байгаа нь тодорхой байсан бөгөөд тэд хотоо бүслэлтэнд бэлтгэж байлаа. Учир нь дайн тулалдаанд мэргэжсэн тэдний дайсан удаан хугацааны бүслэлт хийхээр төлөвлөж байжээ. Хот ч маш сайн бэхлэлтэй болж, олон тооны дайчин эрстэй байлаа. Инал ханы мэдэл дор 50.000 цэрэг байсан ба мөн үүн дээр Хажиб Каражийн 10.000 цэрэг хүч нэмж байв. Инал хан ард олноос дэмжлэг ирнэ гэдэгт итгэж байжээ. Хотод айdas хүйдэс түгэхийн хамт оршин суугчдынх нь хотоо хамгаалах гэсэн хүсэл эрмэлзлийг нь өргөж байлаа. Чингис туршуулзуудаараа дамжуулж, хотод байдал ямар байгааг мэдэж авсан бөгөөд бүслэлт харьцангуй удаан үргэлжилэх юм байна гэж тооцоолсон байлаа. Иймд тэрээр бүслэлтэнд үлдэх цэргүүдийг захирах үүргийг өөрийн хөвүүд Цагаадай, Өгөөдэй нарт шилжүүлэн өгөөд өөрөө бусад цэргэгтэйгээ Бухар хотыг эзлэхээр Мавара ан-Нахрын зүг довтолгосон. Монголын хааны хувьд биеэр ирж Оттараас өшөөгөө авах нь тийм ч чухал байсангүй. Харин хааны аугаа их хүчин чадалд үл итгэгч буюу түүнд занал учруулагч, гомдоогч хэн бүхэнд Оттараар дамжуулан сургамж өгөх гэсэнд нь хэн ч эргэлзэхгүй биз ээ. Тэрээр Бухар уруу довтлох тухай шийдвэрээ тактикийн үндсэн дээр бодож боловсруулсны эцэст гаргасан болов уу. Тэрээр дайныг Оттарын эсрэг бус, харин Шах болон түүний их гүрний төвлөрсөн хүчинүүдийн эсрэг хийсэн юм. Гол цөм хүчийг эхлэн цохиж, дараад нь олон жижиг, дунд зэргийг хотуудад цохилт өгөхийн тулд богино хугацааны дотор дайсныхаа нутгийн гүнд нэвтрэн орох цаг нь болсон байлаа. Ийм чиг баримтлалтай үед түргэн шалмаг, уян хатан байх явдал бол уг дайны үндсэн зарчим болж байв. Энэ нь дайсандaa амсхийж, хүчээ сэлбэх бололцоо олгоогүй бөгөөд монголчуудыг байнга хаана ч байдаг юм шиг сэтгэгдэл төрүүлжээ.

Оттарын бүслэлт бүтэн таван сарын турш үргэлжилсэн. Хоёр тал хоёулаа маш их хүч гаргаж байлдсан бөгөөд олон хүний амь үрэгдсэн. Оттарт өлсгөлөн нүүрлэж, хотыг цааш хамгаалах боломжгүй болох үед хотоо өгөхийг Инал ханаас Харчи шаардсан. Бууж өгнө гэдэг бол Иналын хувьд амия хорлосонтой өөрцгүй зүйл байв. Тэрээр бууж өгөхөөс татгалзаж, 20.000 цэргэгтэйгээ хотод цайзад сууж, тэнд нэг сарын турш монголчуудтай тун бага горьдлоготойгоор тэмцсэн ажээ. 1220 оны II сард монголчууд бэхлэлтийг эвдэн орсон. Иналыг барьж аваад, түүнийг цаазлахын урьдаар цэрэг эрсийг нь түүний нүдний өмнө хядаж байв. Монголчууд хотын оршин суугчдыг барьж аваад толгойн сэргийлэх ангид жагсаан явуулах бөгөөд тэд хотуудыг бүслэх үед газар шорооны ажил хийх эсвэл монгол цэргүүдийн өмнө "амьд бамбай" болж явах ёстой байв. Зөвхөн мэргэшсэн гар урчууд л тэднээс шал өөр байдалд байв. Монголчууд мэргэшсэн гар урчуудыг ихэвчлэн хааны ордныг барих ажилд дайчлахаар илгээж байлаа.

Чингис хааны тушаалаар Зүчи Сырдарьяа мөрний адаг орчмын газарт цэргээ авч ирсэн. Түүний ирсэн анхны хот бол Сигнак хот байлаа. Бүслэлтэнд цагаа дэмий үрэхгүйн тулд тэрээр хот уруу элч илгээж, түүгээр дамжуулж хотын хүн ардыг бууж өгөхийг тулган шаардсан ажээ. Гэвч хотын оршин суугчид элчийг алаад, долоон өдрийн турш ширүүн тэмцэл хийсэн. Монголыг хотыг эзлэн авсны дараа Зүчи хотын оршин суугчдыг бултаар нь цаазаар аваачсан. Сигнакт өрнөсөн тэмцэл ямар аймшигтайгаар төгссөн талаархи мэдээ салхин хурдаар тархсан. Бусад хотууд хэр бага эсэргүүцэл үзүүлснээр нь үүний үзүүлсэн сэтгэлзүйн нөлөөллийг тооцож болох юм. Уцкенд, Баржинлинкенд, Ашна хотууд сүйрсэн. Шахын төлөөний хүн Кутлуг Ханы 10.000 цэргэгтэйгээр хамгаалж

байсан Женд хотыг монголчууд 1219 оны IV сарын 21-нд эсэргүүцэлгүйгээр эзлэн авсан. Кутлуг эгзийг нь тааруулан цэргээ дагуулаад Сырдаръяа мөрнийг гатлан дутаасан. Жендын оршин суугчид харьцангуй их хохирол үзэлгүйгээр өнгөрсөн. Монголчууд хотыг цөмлөн дээрэмдэх үедээ тэднийг хотоос зөвхөн хөөж гаргаад, долоо хоногийн туршид хээр хонуулжээ. Дараад нь л тэд гэр гэртээ харьсан ажээ. Монголчууд лалын шашинт Али Хожаг тэдний захирагчаар томилсон.

Алаг Ноён, Чайс, Сүхэту Черби нараар захируулсан цэрэг Сырдаръяа мөрний эх орчимд дайтаж байлаа. Тэд Бенакет хотыг эзлэн авч, стратегийн чухал Хоженд хотыг эзлэхээр явсан. Тэдний захирагаан дахь нийт 20.000 монгол цэрэг, 50.000 харь цэрэг Хоженд хотыг тойрог үүсгэн бүслэхийг зорьж байлаа. Шахын хамгийн шилдэг цэргийн жанжин болох Дамир Маликын тушаалаар хотыг хамгаалж байв. Гэвч тэрээр гарамгай чадварлаг боловч тун их хүчирхэг дайснаа цохих хэмжээний эсэргүүцэл үзүүлж чадаагүй юм. Дамир Малик цэргээ дагуулан хотыг орхин явахаар шийдсэн. Ингэснээр тэрээр хотын оршин суугчдаас монголчууд өшөө авах явдлаас сэрэмжилэх гэсэн байж магадгүй. Хотоос холгүйхэн Сырдаръяа мөрний дунд орших арал дээр тэрээр 1000 цэргийн хамт бэхлэлт хийн суусан. Аرادл монголчуудын сумны тусгал хүрч чадахгүй байх тул монголчууд арлын зүг далан барихыг оролдож байсан боловч шөнөд нь Дамир Маликын цэрэг эрс даланг эвдэж хонодог байв. Дамир Маликын цөөхөн хэдхэн дайчдын эсэргүүцэлтэй тулгарч монголчууд ихээхэн хохирол амсахаас аргагүй байдалд орсон тухай түүх бичигт онцлон дурдсан байдаг ажээ. Дамир Маликын зэр зэвсэг, хоол хүнсний нөөц дуусах тийшээ хандах үед тэрээр харанхуй шөнөөр цэргээ дагуулан яруухан эвлүүлсэн салаараа Гурганж хотын зүг дутаажээ.

Энэ хооронд цэргийн гол хүч Чингис хааны тушаалын дагуу Бухарын зүг довтолсон. Их цэрэг замдаа Царнук хотыг дайрсан. Хотынхыг ямар нэгэн нөхцөл тавилгүйгээр шууд бууж өгөхийг шаардуулахаар Чингис өөрийн зуучлагчийг хот уруу илгээсэн. Хотын дээд түшмэд шаардлагыг хүлээн авч, Чингис хотыг өршөөжээ. Түүхэнд бичиж үлдээснээр Чингис тэрхүү хотод Кутлуг-Балиг /"Жаргалтай хот"/ гэдэг нэрийг өгчээ. Мөн Нур-и Бухара хэмээх жижиг хот эсэргүүцэлгүйгээр бууж өгсөн. Чингис уг хотын 600 эрийг цэрэгтээ элсүүлэн авч, хотын ард иргэдэд 1500 динарын нэг удаагийн алба төлөхийг шаардсан бөгөөд үүний тал хувийг тус хотын эмэгтэйчүүд өөрсдийн зүүлт, гоёлоороо төлж барагдуулсан ажээ. 1220 оны II сарын 7-нд Чингис хаан цэргээ дагуулан Бухар хотноо хүрч ирсэн. Лалын ертөнцийн хамгийн сайхан хотуудын нэг бөгөөд лалын шашны нэгэн төв болох Бухар хот монгол цэрэг эрсийн нүдний өмнө цэлийж байлаа. Жувэйни энэ хотын шагшин гайхаж, тэмдэглэлдээ бичиж үлдээхдээ: "Тэр бол дорно зүгийн орнуудын хувьд лалын шашны оройн чимэг болох бөгөөд налгар тайвнаараа алдартай Самарканд хоттой эн сацуу юм. Ховорхон заяасан мэдлэг, чадвараараа гайхуулсан эмч, хуульч нар нь гэрэл гэгээ нэмэн, хотыг чимж байлаа. Энэ хот эрт үеэс бүхий л шашны эрдэмтэн мэргэдийн хуран цуглдаг газар байжээ."<sup>20</sup>

Бухар хот цэргийн асар том ангитай байсан бөгөөд Эмир Ихтиар ад-Дин Кушлу болон Огул Инанч Хан нар хотыг хамгаалах үүрэг хүлээж, 30.000 цэргийг захирч байжээ. Монголчууд хотыг тойрон бусэлж хараахан амжаагүй байтал дайсны тал дайралт хийж, монголчууд хариу дайралт хийсэн байна. Эхэндээ тэд монголын талыг шахаж чадсан. Гэвч тэд ихээхэн уршиг татсан алдаа хийж, амжилт бүрэн олоогүй байж цэргийн хүчээ зангидах дайралтыг цааш үргэлжлүүлэлгүй хугацаа алджээ. Ийнхүү тэд эцэст нь монголчуудад бүрэн ялагдсан байна. Хотыг хамгаалж байсан захирагч нараас Ихтиар ад-Дин Кушлу зэрэг цөөхөн хэдхэн нь л зугатаж амжсан. Байдал ноцтой байсны улмаас хотын дээд түшмэд хотыг нэн даруй монголчуудад өгөхөөр шийджээ. Бадр ад-Дин Кади Хан тэргүүтэй төлөөлөгчид хотыг оршин суугчдынх хамтаар өршөөхийг Чингис хаанаас гүйсан байна. Гэвч хотын иргэд эсэргүүцэл үзүүлсэн тул өөрсдийн хувь заяаг хэдийнээ үхэх ялтайгаар шийдүүлсэн байна. II сарын 10-нд монголчууд Бухарт дайран орсон. Шахын цэрэг хотын цайз хэрмэнд бэхлэлт хийж, 12 хоногийн турш горьдлого

<sup>20</sup> Ata-Malik Juvaini, The History of the World-Conqueror, I, Manchester 1958, тал- 97-98.

багатайханаар тэмцсэн. Хотын иргэд өөрсдийн гараар цайз хэрмийг эвдлэхийг Чингис тушаасан. Түүний дайчид энэ хооронд хотыг тонон дээрэмдэж эхэлсэн. Лалын шашны зүтгэлтэн Имам Рукн ад-Дин Имамцада түүний хүү Кади Садр ад-Дин нар лалын сүмүүдийг цөлмөн дээрэмдэж, ариун ном судруудыг сүйтгэн бусниулж байсны улмаас тэд Чингис хаанд эсэргүүцлээ илэрхийлсний улмаас Чингис тэднийг олон таван үггүйгээр цаазаар авахуулсан. Монголчууд хотыг тонон дээрэмдсэний дараагаар оршин суугчдыг нь эзгүй тал уруу хөөж гаргаад, Самарканадад довтлоходоо эрчүүдийг нь толгойн сэргийлэхийн ангид жагсаан оруулаад, эмэгтэйчүүд хүүхнүүдийг нь цэргүүддээ хуваан өгсөн. Дараад нь Бухар хотыг үнс нурманд нь хутгасан. Бухарт болсон аймшигт явдлыг нүдээр үзэж, төдөлгүй Хорезм уруу зугатах аз тохиосон нэгэн эрийн тухай Жувэйни бичихдээ: “Түүнээс хотын хувь заяаг асуухад хариулсан: Тэд ирээд, доройтуулан унагаж, галдан шатаагаад, алж талан, дээрэм тонуул хийгээд одсон.”<sup>21</sup>

Чингис хотыг эзлэн авсны дараагаар хугацаа алдсангүй. Бухараас тархаж буй сэтгэл сэргийлгэж, аймшигт мэдээний сэтгэлзүйн үр нөлөөг тэрээр мэдэж байсан бөгөөд их цэргээ аван Самарканын зүг хөдөлсөн.

Самаркан бол эрт тухайн үед Шахын хоёрдахь нийслэл хот бөгөөд түүхэнд хүн анх суурьшсан Төв Азийн ууган газруудын нэг гэгддэг байлаа. Энд тоо тоомшгүй олон эрдэмтэн мэргэд амьдарч, бүтээл туурвилаа үлдээж байсан. Энд мөн олон зууны тэртээгээс дамжин ирсэн мэдлэгийн санг багтаасан номын сангуд оршиж, гойд чадварлагаар хийц нарийн чамин үнэт зүйлсийг урлах чадалтай гар урчууд энд ажиллахын хамт мөн лалын шашны чухал төв энд оршиж байлаа. Торгоны зам дээр оршиж, зам тээвэр-худалдааны чухал төв болсон энэ хотын нүүр царайг хээнцэр гоё лалын сүмүүд тодорхойлж байжээ. Хотыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээнүүд нь түүний ач холбогдлыг харуулна. Нийт 110.000 цэрэг эрс хотыг хамгаалах үүрэг хүлээдэг байжээ. 60.000 түрэг мөн 50.000 тажик цэрэг Тэркэн хатны дүү Тагай ханы удирдлаганд бэлэн байв. Энэ нь ерөнхийдөө Хорезмын шахын элит цэрэг байсан тухай Жувэйни бичсэн байдаг. Хорь орчим байлдааны заан хөлөглөсөн тусгай ангийн хажуугаар тэдгээр цэрэг нь хэрэм цайзаар хотыг бэхлэж байлаа. Хот ч өөрөө маш сайн бэхлэгдсэн байв. Тэдний хамгаалалтын механизм тун сайн байсан тул “хотыг байтугай хэрэм цайзыг эзэльье гэвэл хэдэн жилээс наашгүй”<sup>22</sup> гэдэгт зарим хүмүүст итгэж байв. Чингис цэргүүдээрээ хотыг бүслүүлэх үедээ хотыг төлөвлөгөөний дагуу эзлэхийн тулд тэрээр хамгаалалтын механизмыг судалж байв. “Чингис хаан өөрийн биеэр нэг, хоёр өдрийн туршид хотыг тойрон явж, хэрэм, хаалга, дамжих зурvas бүхий харуулын цайз/камхаг сэлтийг шалгаж үзсэн бөгөөд энэ үед тэрээр цэргүүдээ тулалдахаас чөлөөлсөн.”<sup>23</sup> Гэж Жувэйни бичсэн байдаг. Ийнхүү шалгаж үзсэний эцэст энэ байдлаар хотыг эзэлж авах нь маш төвөгтэй байх юм байна гэсэн сэтгэгдэл Чингис хаанд төрсөн байна. Иймээс тэрээр байнга шахуу хэрэглэдэг мэхээ хэрэглэхээр шийдэж, цэргийн ихэнхийг дагуулан Самаркандаас гарч явсан. Хотыг жанжин нар монгол цэргийн зөвхөн багахан хэсэг нь хотыг бүслэн хоцорлоо гэж бодоод тэд дайралт хийхээр шийджээ. Самарканын түрэг цэргийн ихээхэн хэсэг монголчуудын эсрэг дайрахад монголчууд зугатах шиг болсон. Гэвч тэд түрэг нарыг занганд оруулж, бүслэн авсны хойно хүчин чармайлт гаргалгүйгээр тэднийг цохиж чадсан байна. Заан хөлөглөсөн хоёр дахь удаагийн дайралт амжилтгүй болж, монголчууд чөдөр оньс хэрэглэн хотыг буудаж эхэлсний хойно хотынхон болон түүний дайчин эрсийн зориг нэлээд их мохсон байлаа. Лалын шашны нэр нөлөө бүхий санваартнууд хотыг монголчуудад өгөхөөр шийдсэн. Кади Шейх ал-Ислам Чингис дээр очоод, хотыг түүнд шилжүүлсэн тухай саналыг дуулгажээ. III сарын 17-ны өдөр монголын цэрэг Самарканад нэвтрэн орж, хоёр өдрийн туршид хотыг дээрэмдэж, хамгаалалтын бүх байгууламжийг эвдлэн сүйтгэсэн. Гуравдахь өдөр үлдсэн 30.000 түрэг цэргийг цаазаар авсан. Кади Шейх ал-Ислам, түүний хамаатан, садан, тойрон

<sup>21</sup> Мөн тэнд 107.

<sup>22</sup> Мөн тэнд 117.

<sup>23</sup> Мөн тэнд 118.

хүрээлэгчид нийт 50.000 хүнийг өршөөж, хотод буцаж ирэхийг тэдэнд зөвшөөрсөн. Толгойн сэргийлэхийн ангид хэрэглэх шаардлагагүй гэж үзсэн хотын оршин суугчдад Чингис 200.000 динар төлсний дараа сая хотдоо үлдэж болно гэжээ. Чингис 30.000 гар урчуудыг монголын угуул нутагт авчрах шийдвэрийг Чингис гаргасан гэдэг ажээ.

Хорезмийн Шахын улсын нэгдмэл цул шинжтэй бусад үлдэх хэсгийг эзлэн авахаар Чингис явсан. Шахыг устгах нь Чингисийн төлөвлөгөөнд стратегийн чухал ач холбогдолтой байлаа. Монголын хаан энэ хэцүү үүрэг даалгаврыг өөрийн гарамгай жанжин нар болох Зэв, Сүвээдэй нарт даалгаж, тэд хоёр арван мянгат дагуулан Шахыг нэхсэн. Шах Мухаммад гарах гарцгүй болсноо ойлгоод дутаасан. Тэрээр Каспийн тэнгисийн нэгэн арал дээр ирж суух хүртлээ нэг хотоос нөгөө хот уруу, нэг цайзнаас нөгөө цайз уруу дамжин зугатаж явсан. Тэнд тэрээр өөрийн хан хөвүүдтэй уулзаж, хэн нь чухам хаан ширээг залгамжлах вэ гэдэг асуудлыг шийдвэрлэсэн. Хөвүүдтэйгээ тэрээр ярилцахдаа хэлсэн нь: "Хүчний нэгдмэл байдал алдагдаж, хүч чадлын тулгуур багананууд сулран доройтож, нуран уналаа. Энэ дайсан ямар зорилготой гэдэг нь тодорхой. Тэрээр савар, шүдээ манай улсын хувьд улам л гүн шигтгэж байна. Миний хүү Манкбурни миний өшөөг авч өгч чадна. Иймд би түүнийг хаан ширээг залгамжлагчаар томилж байна."<sup>24</sup> Шах Мухаммад ийнхүү Манкбурнитэй холбогдсон ийм шийдвэр гаргаснаар нэгэнтээ хатан эх Тэркэнтэйгээ ярьж тохирсон байсан хаан ширээний залгамжлагчийг хүчингүй болгосон. Жалал ад-Дин Манкбурнийн сонгосон түүний энэ шийдвэр нь нөхцөл байдалд тун сайн тохирч байлаа. Ухаан, хүч, нелөөлөх чадвар, цэргийн эрдэм зэрэг хүчтэй удирдагч хүний шинж чанаруудыг өөртөө цогцлоосон нэгэн байлаа. Гэвч тэрээр энэ шийдвэр хэт оройтуулж гаргасан байна. Монголын цэрэг бараг хэдийнээ улсын бүх газар нутгийг захирах болсон байв.

Чингис өдгөө цэргээ дагуулан Хорезмын зүрхэн тус газар нийслэл хот Гурганжийг эзлэхээр довтолсон. Хорөзмыг өдий болтол монголчууд бүрэн эзлээгүй байсан нь Амударьяа мөрний бэлчирийг багтаах энэ газар нь олон талаараа Каракум, Кызылкумын цөлөөр гадаад ертөнцөөс тусгаарлагдсан байв. Монголын цэрэг Амударьяа мөрнийг гэтлэн Гурганж уруу дайрсан. Хот маш сайн бэхлэгдсэнд тооцогдох бөгөөд удаан хугацааны бүслэлтийн үед өөрийгөө хамгаалах чадалтай байлаа. Хүч нөлөө бүхий Тэркэн хатан ч монголчуудын эсрэг лавтайя шаргуу тэмцэнэ байх гэж санагдахуйц байлаа. Гэвч монголчууд Гурганжад ойртон ирмэгц, Тэркэн хатан тун гайхалтайгаар хотыг орхин явж, Мацандаран дахь Илал цайзад шургалан орсон. Илал цайзыг бүслэлтэндээ авахын тулд монголчууд Гурганжийг орхиход хүргэсэн. Илал цайз монголчуудын дайралтыг дөрвөн сарын турш барьсан. Дараад нь Тэркэн хатан монголчуудад бууж өгөхөөс аргагүй байдалд орсноо ойлгосон. Тэркэн хатныг Шах Мухаммадын хүүхдүүд, ордны татвар эмсийн хамтаар монголчууд барьж аваад Тэркэн хатныг дорд басамжилсан нөхцөлд насан эцэс болтол нь амьдруулахаар Чингисийн угуул нутаг уруу илгээсэн ажээ.

Энэ зуур Гурганжад дотоодын тэмцэл үргэлжилж, хотод нэг талаар эмх замбараагүй байдал үүсгээд байлаа. Улсын Диван гэдэг дээд байгууллагын түшмэд хүрч ирснээр энэ байдал эцэс болсон. Жалал ад-Дин Манкбурни, Уцлаг Шах ба Ак Шах нар хотод хүрч ирснээр тэмцлийн гал дахин бадарсан. Тэркэн хатны төрөл садан ба түүнийг дагагсад Жалал ад-Диныг шинэ эзэн хэмээн хүлээн зөвшөөрөхөд бэлэн биш байсан. Тэд Тэркэн хатны дүү Хумар Тэгинийг султанаар сонгосон байлаа. Хумар Тэгин 90.000 цэрэг захирч, цэргийн илт давуу хүчтэй байж, ихээхэн аюул заналхийлж байсан тул Жала ад-Дин ба түүний ах дүү нар цэргээ дагуулан хотоос гарахыг илүүд үзсэн. Төдөж удалгүй Өгөөдэй, Цагаадай, Толуй Черби нарын удирдлаган дор монгол цэрэг Гурганжийг бүсэлж, хотыг хүнд чөдөр оньсоор буудаж эхэлсэн. Энэ нутагт буудахад тохирох чулуу хангалттай бус байснаас монголчууд ялмын модыг чулуу шиг жинтэй болтол нь усанд

<sup>24</sup> З. М. Бунийтов, Государство Хорезмшахмаков-Ануштегинидов (1097-1231), Москва 1986, тал-148.

дэвтээж байлаа. Тэд хотоо цөхрөлтгүй тууштайгаар хамгаалан тэмцэж байв. Монголчууд Самарканд эзлэхэд хэрэг болсон тэр мэхийг дахин хэрэглэхээр шийдсэн. Гэхдээ хэрвээ тэд цэргүүдийг зарим хэсгийг хотоос гаргаж, дарсан нөхцөлд л энэ арга үр дүнгээ өгөхүйц байлаа. Хотын зүгээс үзүүлж буй эсрэгүүцлийг тэд зогсоож дийлэхгүй байсан. Энэ үед Зүчи цэргэгтэйгээ хүрч ирсэн. Монголын бусад жанжин нартай харьцуулахад Зүчи Гурганж хотыг эвдлэн сүйтгэхийг сонирхохгүй байлаа. Чингис том хүүдээ Мавара ан-Нахр, Хорезм орчмын газрыг өөрийнх нь эзэмшил болгон зааж өгсөн байв. Хотыг хэрхэн эзлэн авах талаар Зүчи, Цагаадай хоёр санал зөрсөн. Зүчи хотыг эзлэн авахдаа хэлэлцээр, тулган шаардах замаар шийдвэрлэхийг шаардаж байхад Цагаадай цэрэг зэвсгийн замыг сонгож байлаа. Хотын бүслэлт удааширан. Зүчийн хотын тэргүүн нартай хийсэн хэлэлцээ үр дүнгүй өнгөрсөн. Бүслэлт долоон сар үргэлжлээд бас л хэзээ дуусах нь тодорхойгүй байв. Чингис цэргээ ийм хэт удаан хугааанд Гурганжад байхыг тэсвэрлэж чадсангүй. Бэхлэлт сунжирсны гол шалтгаан нь Зүчи, Цагаадай нарын зөрчилдөөнд байна гэдгийг Чингис ойлгож, Гурганж дахь цэргийг захируулахаар Өгөөдэйг явуулсан. Өгөөдэй очоод хотыг богино хугацааны дотор буулгаж авч чадсан. Тэгэхдээ монголчууд хотын алга дарам газрын төлөө маш их хохирол амсан тэмцэж байв. Горьдлого бага байсан ч хотын оршин суугчид хотоо хамгаалан тэмцэж байлаа. Монголчууд тэднээс өшөөгөө авах нь тодорхой байсан юм. Хотыг эзэлж авсны дараагаар монгол цэрэг тус бүр 24 хүнийг өөрийн гараар алсан гэж түүх бичигт дурдсан байдаг. Энэ тоог дэгсдүүлсэн байх магадлалтай ч цусан өшөө авсан нь бараг эргэлзээгүй юм. Монгол уруу илгээсэн байж магадгүй гэх гар урчуудын тоог 100.000 байсан гэдэгт болгоомжтой хандах хэрэгтэй байх. Түүхчдийн бичсэнээр эмэгтэйчүүдийг нүцгэлж, хотынхны өмнүүр явуулсан гэдэг. Тэдгээр эмэгтэйчүүдийг хоёр хэсэг болгон хуваагаад тушаасан нь: “Танай хотын эмэгтэйчүүд бол маш сайн нударган зодоочид учраас хоёр талын эмэгтэйчүүд хоорондоо нударган зодоо хийж эхлэхийг бид тушааж байна.”<sup>25</sup> Энэ нь амьд үлдсэн эмэгтэйчүүдийг монголчууд өөрсдийн гараар алсан гэсэн үг юм. Үүний дараа хотыг хэрэмний ёзоор хүртэл эвдлэн сүйтгэж, Амударъяа мөрний усанд автуулсан.

1220 оны зун монголчууд Хорезмд хийсэн аян дайнаа дуусгаад Хорасан уруу хөдөлсөн. Тэндэхийн хот, цайзуудыг маш амархан эзлэн авсан. 1221 оны зөвхөн зун, намар л гэхэд Балх, Тэрмэц, Цауцан, Андхуд, Мөрв, Нишапур, Тус, Херат зэрэг хотууд эзлэгдэн сүйрсэн. Шахын улс үнэндээ оршин тогтоноо больсон байлаа. Шах өөрөө 1220 оны 12-р сард Каспийн тэнгисийн арал дээрээ нас барсан байв. Нэгэнтээ бусдыг өмнөө сөхрүүлж, чихнээ сонсголонтой сайхан алдар цолыг дуурсгаж явсан эзэнтэн маань ганцаардал, үнэ хүндгүй байдалд тэнгэрт хальжээ. Түүний хүүрийг Өгөөдэй хожим шатаалгасан байна.

Шахын хүү-Манкбурни Чингис хааны эсрэг их цэргийг цуглуулах гэж нэгэн удаа оролдсон. 1221 онд Шахын садангийн хүн болох Амин ал-Мулк 10.000 цэрэгтэйгээр түүн үрүү довтолсон ажээ. Үүний хариуд Афган, Харлук, Халажи, Балхын тэргүүн нартай Жалал ад-Дин Манкбурни холбоо байгуулж, өөрийн тушаал дор цэргийг нэгтгэсэн. Монголын багахан цэрэгтэй дайтсан эхний тулалдаан амжилттай болсон бөгөөд эцэст нь Шигихутугаар захириулсан 45.000 байлдагч бүхий цэрэгтэй Манкбурни нүүр тулсан. Хоёр өдөр үргэлжилсэн тулалдаанд монголчууд айхавтар ялагдсан. Шигихутуг Чингис хааны ордон уруу дутаажээ. Гэвч энэ том ялалт Манкбурнид магадгүй гай болсон байх. Түүний цэргийн жанжин нар дайны олзоо хуваахдаа муудалдан хоорондоо тэмцэлдэж байх зуур Чингис хаан тэднийг хэдийнээ хойноос нь мөшгөөд эхэлсэн байлаа. Монголын шилдэг цэрэг тэднийг нэхэн ойртсоор байлаа. Манкбурни цэргийнхээ хамтаар зугтаасан боловч Индус голын эрэг дээр монголын толгойн сэргийлэхийн анги түүнийг зогсоосон. Гурван өдрийн туршид талууд ширүүн тулалдсан. Гуравдахь өдөр буюу 1221 оны XI

<sup>25</sup> З. М. Бунятов, Государство Хорезмшахмаков-Ануштегинидов (1097-1231), Москва 1986, тал-153.

сарын 25-нд Жалал ад-Дин долоон зуухан цэрэгтэй хоцорсон. Байдал ямар ч найдваргүй болмогц Жалал ад-Дин морьтойгоо Индус голд үсрэн орж, цаад эрэг дээр мэнд гарч иржээ. Ийн дутаагсдыг Чингис үзээд ихэд гайхаж, “Эцэг хүн зөвхөн ийм л хөвүүдтэй байх ёстой”<sup>26</sup> гэж хэлсэн гэдэг.

Чингис хаан Манкуурнийг ялснаар Шахын улсын хуучин нутагт дүрэлзэн асаж байсан тэмцлийн сүүлчийн галыг унтраасан.

Бид эргэн санацгаая: Тус улс умар зүгт Арап тэнгистэй, өмнө тийш Персийн булан, зүүн зүгт Памирийн нуруу, баруун тийш Цагрос нуруутай хааяа нийлдэг байсан... Шахын улс хойноос урагшаа нийтдээ 1200 орчим км, баруунаас зүүн тийшээ 2500 орчим км үргэлжлэн оршдог байсан. Чингис хааны Шахтай хийсэн дайн 1219 оны 9-р сард эхлэн, 1220 оны зун дууссан. Ингэхлээр дайн бол ердөө нэг жил л үргэлжилсэн байна. Энэ нэг жилийн дотор Отрап, Хоженд, Бухар, Самарканд, Гурганж, Нишапур, Херат зэрэг алдартай, тухайн үедээ цайз хэрмээр онцсайн бэхлэгдсэн гэх хотууд сүйрэн унасан. Олон хотууд эсэргүүцэл үзүүлэлгүйгээр бууж өгсөн бөгөөд бусад хотуудыг цөөн хоногийн тулалдааны дараа буулгаж авч байсан. Зөвхөн Гурганж л хэдэн сарын туршид эсэргүүцэл үзүүлэн тэмцсэн юм. Энэхүү харьцангуй богино хугацааны дотор дор хаяж 540.000 хүнтэй байсан Шахын их цэргийг хэдийгээр тэднийг сайн зэвсэглэсэн, дайнд гарсан гэдэг байсан боловч юу ч үгүй хиаруулсан ажээ. Энэ үед монголчууд Амударъя, Сырдаръя мөрөн зэрэг усан саад, цөлийн болон уулын бүсийн бэрхшээлүүдийг даван туулсан. Тэдний цэргийн хүч чадал асар их байсан. Ийм түргэн хугацаанд амжилтанд хэрхэн хүрсэн бэ?

Бусад тохиолдлуудын нэгэн адил Чингис хаан цэрэг-стратегийн тооцоог хийхдээ дайснаа бодвол илүү сайн бодож боловсруулдаг байсан. Түүний хамгийн гол тулгуур нь төвлөрсөн, хатуу зохион байгуулалттай цэрэг байсан бөгөөд энэ цэргийг хааныхаа тушаал бүрийг эрч хүч, туйлын их тэсвэр тэвчээртэйгээр биелүүлдэг, шалгарсан цэргийн жанжин нар захирч байжээ. Түүний цэрэг төмөр шиг хатуу чанд дэглэмтэй байсан бөгөөд дэглэм нь зөвхөн хааныхаа тушаалыг л биелүүлэх явдалд чиглэгдсэн байх тул хааны тушаалыг дагаагүй буюу биелүүлээгүй хэн бүхэн үхэх ялтай байжээ. Цэргийн жанжин нар ч энэ журмын гадуур үлдэггүй байв. Сүвээдэй жанжны бэлтгэл цэргийг захирч байсан Тогачар тулалдаан эхлэх үед Чингис хааны тодорхой тушаалгүйгээр лалын шашинт ноёны эзэмшил хотуудыг тонон дээрэмдэж, хотын захирагч ноёныг Шахын тал уруу хөөсөн тул Тогачарт алах ял оноох гэж байжээ. Харин тэрээр цэргийн албанаасаа хөөгдөх төдий өнгөрсөнд бусад гавьяа шагналт цэргийн жанжин нар түүнийг өмгөөлсөн явдалд талархааас аргагүй юм.

Дайтахад хамгийн чухал чанар болох түргэн шуурхай, уян хатан байдлыг Чингис хаан тактик зохиохдоо харгалзан үздэг байв. Хамгийн богино хугацааны дотор байрлалаа сольж, хол зам туулах чадвартай морин цэргээс түүний цэргийн ихэнхи хэсэг нь бүрддэг байсан нь дээрхи хоёр чухал чанар урган гарах үндэс болж байсан юм. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд зэр зэвсгээр хангах, засаж сэлбэх үйлчилгээг хийх тохиромжтой бааз суурьтай байх хэрэгтэй бөгөөд энэ бааз суурийг бүрдүүлдэг гол зүйл нь цэрэг эрсийн эхнэр, хүүхдийг хамтад нь хөсөг тэргэнд авч явдаг ар талын алба байлаа.

Гэхдээ цэрэг эрсийн байнга ганзагалан биедээ авч явах хоол хүнс нь тэдэнд ар талын албаны хангамжаас тодорхой хэсэг хугацааны туршид хамааралгүй байх боломжийг олгодог байжээ. Цэрэг бүр хуурай сүү эсвэл айраг /бага хэмжээгээр/ борц, ааруул, бяслаг болон нунтаг борцыг хоёр ширэн уутанд хийгээд өөртөө авч явдаг байсныг бид бүгд мэдэх билээ. Чингэхдээ махыг тусгай аргаар боловсруулдаг байсан бөгөөд энэ аргыг олон зууны тэртээгээс өнөөг хүртэл мөн л хэрэглэсээр л байна. Үүнд үхрийн махыг давстай усанд чанаж, дараад нь хатаагаад, эцэст нь нунтаглан нухдаг. Бүх л бүтэн шар үхрийн махыг ийм аргаар боловсруулж хатаахад ганцхан гүзээнд багтдаг

<sup>26</sup> Рашид ад-Дин. Сборник летописей. Том I. Книга вторая. Москва, Ленинград. 1952. тал-224.

тухай Бямбын Ринчен дурсан бичсэн байдаг. Жүгдэрийн тооцоолсноор<sup>27</sup> монгол цэрэг бүр ойролцоогоор хоёр кг борц авч явдаг байсан нь хоёроос турван сарын /шар будааны хамтаар/ хүнс болдог байжээ. Мэдээж ийм хүнстэй ганзагыг дээрэмдэх булаах явдал гардаг байсан байна.

Монгол морьд дайныг шуурхай, түргэн, уян хатан явуулах бололцоог олгодог. Манай Европ зүгийн морьдыг бодвол монгол морьд жижигхэн боловч булчинлаг, тэвчээртэй бөгөөд Шахын улсын өргөн уудам тал нутгийн ургамлын аймаг, уур амьсгалын хувьд ерөнхийдөө Монголынхтой төстэй байсан учраас монголчууд морьддоо бэлэн тэжээл тавьж өгөх шаардлага байсангүй, харин тэд зам зуураа бэлчээрлэж өөрсдөө хооллоочиждог байв.

Зүрчидийн улсад аян дайн хийснээс хойш монголчууд хөрш орнуудынхаа цэргийн зэвсэг техникийг ашиглаж сурсан. Энэ нь ялангуяа бүслэлт хийхэд хэрэглэх техникийг хэрэглэж сурсантай холбогдоно. Хэрэм цайзаар бэхлэн тулалддаг батлан хамгаалах чиг баримтлалтай учраас Шахын улстай дайтахад Умард Хятадад ийм төрлийн техниктэй харьцаж олсон туршлага, чадвар нь хэрэг болж байжээ.

Чингис хаан дайны төлөвлөгөөг хийхдээ довтлох гэж буй улсаа сайтар мэдэж ойлгож авдаг байсан нь түүний үйл ажиллагаа амжилттай болохын чухал урьдач нөхцөл болдог байсан. Ингэхдээ тэрээр дайсныхаа цэргийн холбогдолтой мэдээллийг төдийгүй мөн юуны урьдаар дайсан этгээдийнхээ засан захираг тогтолцоон дахь болзошгүй сүл талуудыг анхаарч үздэг байв. Баруун зүг хийх аян дайнд бэлтгэхэд лалын худалдаачид түүнд тагнуул туршуулын чухал албыг залгуулсан юм. Ялангуяа Түрэг, Монгол, Хятадад жин тээн худалдаа эрхлэх арилжаа наймаачид Чингис хаанд дэмжлэг үзүүлэх онцгой сонирхолтой байжээ. Учир нь тэд Чингис хааныг их хаан болж, ирээдүйд их гүрэн байгуулаад, худалдааны онцгой таатай нөхцлийг өөрсөд нь олгоно гэж тооцож байсан ажээ.

Шахын улсад Чингис хааны цэрэг шуурхай, амжилттай дайтсан шалтгааныг монголчуудын аян дайн хийх давуу сайн талуудтай зөвхөн холбож ярих нь буруу байх л даа. Шахын улсын дотоод байдал, Шахын алдаатай буруу шийдвэр гаргасан зэрэг олон тооны гадаад хүчин зүйлс нь монголчуудад цэргийн аз тохиох нэн таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм. Мөн улс ба цэрэг нь угсаатны холимог бүтэцтэй байж, зөрчил гарах байнгын суурь дотор нь амь бөхтэй оршсоор байсан, лалын шашныхан, нутгийн язгууртан ноёд, ард түмний зүгээс ихэнх нь Шахын бодлогыг сайтар дэмжиж өгөхгүй байсан зэрэг хүчин зүйлс нэмэгдэж орно. Батлан хамгаалах чиг баримтлалаа зөвхөн хэрэм цайз, сайтар бэхлэлт хийсэн хотуудыг л түшиглэж байхаар Шах шийдвэрлэсэн нь эргэлзэнгүйгээр хамгийн муу нөлөөг үзүүлсэн юм. Ингэснээр түүний асар том цэрэг задарч, янз бүрийн хотуудад тараагдсан. Монголчуудынхтай нэгэн адил Шахын цэрэгт морин цэрэг хамгийн гол цөм нь болж байсан учраас хэрэм цайзаар хамгаалалт хийх тактик баримтлахад цэргийн цохилт өгөх хүч алдагддахаас аргагүй юм. Дээрээс өгсөн тушаал пирамид хэлбэрээр дамждаг тогтолцоо нь цэргийн үйл ажиллагааг уялдуулах боломжийг үүгүй болгодог. Зөвхөн нэг хотыг л хамгаалж байхад хот дотор хэд хэдэн цэргийн жанжин өөр өөрийн цэргийг захираг учраас тэднийг хооронд нь уялдуулна гэдэг боломжгүй зүйл байв. Үүний дээр цэрэг эрсийн хүсэл зоригийг бадраах гэдэг нэг асуудал яригдах ёстой. Бид Самарканыг жишээ болгон авьяа л даа. Хотыг хамгаалахаар түрэг, тажикууд ирсэн байлаа. Гэтэл уг хотод иран угсааны хүмүүс судаг байв. Оршин суугч суурьшмал иргэд ба тэднийг хамгаалан дайтагч нүүдэлчдийн хоорондын соёлын асар их ялгаанаас л ганцхан аваад үзэхэд тэдний батлан хамгаалах хүсэл зорилгын хувьд ч ихээхэн ялгаа гарах юм. Нүүдэлчин угсааны цэргүүд ихэвчлэн хол нутгаас ирсэн бөгөөд нутагт нь гэр орных нь хоцорсон байх тул тэдний одоо монголчуудын довтолгооноос хамгаалах гээд байгаа хот, улс тэдэнд огт падгүй байлаа. Монголчуудын эсрэг богино хугацаанд боловч тэр хэмжээгээрээ ихээхэн хүчтэй эсэргүүцэл үзүүлж байсан хүмүүс бол бараг цөм хотын оршин суугчид байсан гэдгээр үүнийг хялбархан тайлбарлаж

<sup>27</sup> Ч.Жүгдэр. "Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг" номыг үзмүй.УБ., 1990 он.

болно. Чингис хааны цэрэгт олон түрэг угсааны цэргүүд тулалдаж байсан бөгөөд тэд Шахын талд дайтаж байсан түрэг угсааны цэргүүдтэй магадгүй цусан болон бусад төрлийн холбоогоор холбогдсон байж болзошгүйг дурдалгүй орхиж болохгүй.

Шах ба түүний цэргийн жанжин нар Чингис хааны эсрэг хүчтэй эсэргүүцэн тэмцэх чадваргүй байсан явдалд лалын шашинт ард түмний сэтгэхүйд байх нэгэн сэтгэлзүйн хүчин зүйл нөлөөлсөн юм. Алан хядлага гэдэг бол Чингис хааны сэтгэлзүйн зэвсэг байсан тухай хэдийнээс ярьдаг билээ. “Дэлхий өртөнцийн сүйрлийг тэр үеийг хүртэл түрэгүүдтэй холбож ойлгодог хотын ард түмний мэдрэхүйд маш гүн гүнзгийгээр оруулж өгөхөд аллага хядлага нөлөөлсөн шиг санагдаж байна. Аллага хядлага хотын ард түмнийг байнга бухимдуулах болсноос хойш үүнийг утга агуулгын хувьд хэрхэн хөгжиж ирснийг шашны онол-дeterminist үзлээр тайлбарлаж, нүгэл, чивэлт муу хэрэг хийсний төлөө гэсгээж буй “бурхны шийтгэл” хэмээн “дээд хүч”-тэй холбон ойлгох болсныг орхигдуулж болохгүй... Бурхнаас үзүүлж буй гэсгээл шийтгэлийг түрэгүүдтэй холбох энэ төсөөлөлд мөн сайн, муу зүйлс зүүн зүгээс ирдэг гэсэн нийтэд тархсан бодол дээр нь нэмэгдэж орсон. Дорно зүг бол тэдний хувьд сэтгэл түгшин хүлээж байх гайхамшиг, нууцлаг зүйлийг өөртөө агуулж байдаг бөгөөд домог үлгэр, тухайн үеийн үйл явдал хоёр нягт холбогдож, энэ нь бараг батлагдаад байх шиг байгааг харж байгаа учраас үүнд тэд гайхаагүй юм.”<sup>28</sup> Энэхүү сэтгэлзүйн хүчин зүйл нь идэвхгүй, хувь заяагаа дуулгавартайгаар дагаж байх явдлыг бий болгосон бөгөөд энэ нь цаашлаад монголчууд үтэр түргэн хугацаанд ялалт байгуулах таатай хөрсийг бэлтгэж өгсөн юм.

Лалын орнуудад хийсэн монголчуудын довтолгоо нь тэндэхийн улс орон, ард түмний түүхэнд эргэлтийн үеийг авчирсан юм. Ойрхи ба Дундад Дорнодын тогтолцоо бүхлээрээ чичрэн доргиж, ялангуяа эсэргүүцэл үзүүлсэн буюу эрхшээлдээ оруулсан улс орнуудад энэ нь хүчтэй илэрсэн юм. Цэцэглэж хөгжиж байсан Самарканд зэргийн алдартай хотууд балгас болон хувирч, хүн амынх нь ихэнх хэсгийг хядаж, цөлөх юм уу эсвэл албадан хөдөлмөрлүүлж байлаа. Асар том Самарканд хотод л гэхэд монголчуудын довтолгооны дараа хүн амын зөвхөн дөрөвний нэг нь л амьд үлдсэн байв. Өлсгөлөн, тахал үлдсэн хүмүүсийг хамж байлаа. Самаркандын ойролцоо хөдөөгийн хүмүүс ч өлгөлөнд нэрвэгдэж, ядарч туйлдаж байв. Тариан талбайг сүйтгэж, усжуулалтын байгууламжийг эвдэлсэн байлаа. Бухар хотын байдал бүр ч хөөрхийлөлттэй байлаа. Чингис хааны цэрэг хотыг галдаан шатаасан төдийгүй 1238-1316 онуудад хотыг таван удаа довтолж, газар хөдөлж гамшиг болсон адил болгосон байлаа. Ихэнхи хотууд монголчуудын довтолгооны дараа нэг ч амсхийж чадаагүй бөгөөд тэдний хөгжил зогсонги байдалд орж, үүний үр дүн эдгээр газруудад гар урлалын үйлдвэрлэл унасан. Харин монголчуудын довтолгоонд өртөхөөс өмнө тэдгээр хотуудын нэр төр, гэрэл гэгээ болж байсан баялаг сайхан эрдэм ухааны хөгжил цэцэглэлтийн талаар ярихын ч аргагүй болсон байлаа. Хүн амын тоо буурсан нь нийтлэг үзэгдэл болж байв. Хэдэн арван жилийн туршид хотын өмнөх оршин суугчдын хүүрний яс монгол цэргийг явсан мөрийг гэрчилж байлаа. Армений маршал Земпад 1248 оны 2-р сарын 7-нд Кипрын хаанд Самиркандаас бичсэн захидалдаа энэ нутгийн тайтгараахын аргагүй өрөвдөм байдлын талаар гомдоллон ийн бичжээ: “Татаруудаар (монголчуудыг хэлж байна/зохиогч) сүйтгүүлж, эл хуль эзгүйрсэн энэ олон хотуудын талаар би юу хэлэх вэ дээ? (Дээр үеийн) Хангалиун сайхан амьдрал, хөгжил цэцэглэлтээр бялхаж байсан гэж хэн ч одоо төсөөлж чадахааргүй болсон хотууд ... Татаруудын алсан хүмүүсийн хүүрний ясыг овоолж тавьсан зуу бүр мянгаас хол давах том том овоолгооснууд маш эвгүй харагдаж байгааг дүрсэлжээ”<sup>29</sup> Өөр бусад аяны хүмүүс ч мөн иймэрхүү байдлын талаар бичсэн байдаг.

<sup>28</sup> K. Lech, Das Mongolische Weltreich, Al-Umaris Darstellung der mongolischen Reiche in seinem Werk Masalik al-absar fi mamalik al-amsar, (= Asiatische Forschungen, Bd. 22), Wiesbaden 1968, тал-7.

<sup>29</sup> Brief des Marschalls von Armenien an den Koenig von Cypern, in Wilhelm von Rubruk, Reise zu den Mongolen 1253-1255, (= Veroeffentlichungen des Forschungsinstituts fuer Vergleichende

Монголчуудын довтолгооны нэгэн чухал үр дагавар бол Дорнод Туркестаны, хожмын Казахстаны нутгаас нүүдэлчид голцуухан түрэг угсааны нүүдэлчид бөөн бөөнөөрөө Мухаммад Шахын улсын нутагт орж ирсэн явдал болжээ. Нүүдлийн малчид тариалангийн газрыг эзэмшилдээ авч, бэлчээр болгон хувиргаж байлаа. Тариалангийн газрыг зарим нэг талаар дахин сэргэшгүйгээр сүйтгэсэн нь үлдсэн суурьшмал иргэдийн амьдралын эх үүсвэрийт үгүй болгосон байна.

Үүнээс үүдэн хүн амын тоо толгой буурсан мөн хүн амын зарим хэсгийг бүхэл бүтнээр еөр газар хүчээр шилжүүлсэн зэрэг нь тэнд аж ахуйн хөгжил удаан хугацаанд ноцтойгоор зогсоход зайлшгүй хүргэж байлаа.

Шах Мухаммад ба хаан ширээ залгамжлагч Жалал ад-Дин Манкбурнийг ялснаар монголчууд эзэлж авсан газрууддаа өөрсдийн байнгын төлөөллийг бий болгох шаардлагатай тулгарсан. Учир нь зарим нутгийн ноёд монголчуудын эсрэг тэмцэж босох оролдлогыг байн байн хийж байсан юм. Гэвч тэдгээр ноёдын хувьд тэд өөрсдийн эрх мэдлээ нэмэгдүүлэх тухай л зөвхөн яригдаж байснаас тэд төвийн нэгдмэл хүчнийг бий болгож, бусад ноёдтой хүчээ нэгтгэх сонирхолгүй байлаа. Иймд монголчуудын үзэхэд эзлэгдсэн орнууд тун найдваргүйд тооцогдож байсан юм. Жишээлбэл Зэв, Сүвээдэй нар Их хаандаа яаралтай элч довтолгох үедээ элчийг 300-400 цэргээр жич хамгаалуулан явуулдаг байсан тухай Рашид ад-Дин бичсэн байна.

Чингис баруун зүг аян дайнаа хийж дуусгасны хойно эзэлсэн газрууддаа өөрийн төлөөний захирагч нарыг томилох болсон нь түүний улс төрийн ойлголцол нэмэгдсэний илрэл хэмээн ойлгогдож байв. Цөөхөн хэдхэн түүхэн шастирт онцлон тэмдэглэсэнчлэн Чингис Найман аймгийг эрхшээлдээ оруулснаас хойш тэрээр Уйгур, Кидан, Зүрчид, Лалын мэргэд, түшмэдээр өөрийгөө илүү ихээр хүрээлүүлэх болсон. Энэ нь ордныхоо өнгө төрхийг энэ мэт байдлаар сонирхолтой хүмүүсээр засах гэсэн хятадын хааны ордонд элбэг байсан шиг тийм бодлын үүднээс Чингист лавтайяа чухал байсангүй. Чингис прагматик хүн байсан. Асуудалд бодитоор ханддаг Азийн ноёдын оюуны хэрэгцээний талаар тэрээр юу ч мэддэггүй байлаа. Эдгээр эрдэмтэн мэргэдийн дэргэд байх нь харьцангуй өндөр хөгжилтэй хөрш орнуудынхаа эрдэм мэдлэгийг өөрийн болгох боломжийг түүнд илүү олгож байсан бөгөөд энэ нь монгол хаан сурч боловсрох хүсэлтэй, чадвартай болохыг илэрхийлж байв. Цаашлаад Елюй Чуцай, Ялавачи, Чанчуун зэрэг эрдэмтэн, түшмэл, лам нар хааны улс төрийн үзэл бодол, ертөнцийг үзэх үзэлд чамлалтгүй нөлөөг үзүүлж чадсан юм.

Киданы Ляо улсыг үндэслэн байгуулагчийг шууд залгамжлагч Елюй Чуцай нь Жин хааны түшмэл байв. Түүнийг маш өндөр боловсролтой нэгэн хэмээн үздэг байжээ. Конфуцигийн уламжлалт хүмүүжилтэй энэ түшмэлийг бусад кидан нарын нэгэн адилаар 1218 оны 4-р сард Чингис хааны албанад шилжүүлсэн бөгөөд тэрээр мөн Чингис баруун зүг байдан дагуулал хийж байх үед түүний дэргэд зурхайч хийж байжээ. Тэрээр зарим зүйлийг урьдчилан үнэн зөвөөр хэлж байсан нь Чингис түүнийг өөрийн дэргэд шадарлуулахад нөлөөлсөн гэдэг.

Өрнө зүг хийсэн байдан дагуулал дууссаны дараа Ялавачи ба түүний хүү Масут монголын хааны ордонд хүрч ирсэн. Тэд урьд нь Шахын засаг захирагааны байгууллагад түшмэдээр ажиллаж байсан байж болзошгүй гэдгийг харгалзан үзэх хэрэгтэй. Тэд Чингис хаанд "балгасны ёс төрийг"<sup>30</sup> тайлбарласан тухай Монголын Нууц Товчоонд дурдсан байдаг. Тэдний яриа монголын ноёдыг ятган үнэмшүүлж чадсан бөгөөд хотуудыг захирах үүргийг тэдэнд Чингис даалгасан байна. Бухар, Семисген(?) зэрэг хотуудыг монголын талын төлөөний захирагч нартай хамт захирах тушаалыг Масуд хүлээн авсан. Харин Ялавачиар Жунду захируулахаар болжээ. Хожим Чингис хаан тэр

Religionsgeschichte an der Universitaet Leipzig, II. Reihe, Heft 13, uebersetzt und erlaeutert von Dr. Friedrich Risch, Leipzig 1934, тал-7.

<sup>30</sup> Index to the Secret History of the Mongols, by Igor de Rachewiltz, (= Uralic and Altaic Series, Vol. 121), Bloomington 1972, 10815-10818.

хоёрт нийт Зүрчтийн газар нутгийг захируулахаар даалгасан тухай Монголын Нууц Товчоонд бичжээ.

Гайхамшигт рид чадлынх нь тухай сураг чимээ монголын хааны ордон хүртэл тархсан Чанчунь бомботовой уулзахыг Чингис хаан эрт үеэс хүссээр ирсэн ажээ. Харин энэ уулзалт 1222 оны хавар Хиндукушийн өмнө хэсэгт болсон. Үхлийн тухай эргэцүүлэн бодож эхэлдэг цаг үе гэж хүнд байдаг бөгөөд тэр үе Чингист мөн иржээ гэдгийг Хааны асууж сонирхож байсан зүйлээс тодорхой харагдаж байна. Бусад ард түмний нэгэн адил монголчуудад ч гэсэн "мөнхийн амьдрал"-ын тухай төсөөлөл байдаг. Нуудэлчин хүний ёсоор мөн тийм л төсөөлөлтэй байсан Чингис хаан Чанчунь бомбо "мөнхийн амьдрал"-д хүргэх аргыг эзэмшсэн хэмээн сонссон байв. Ингээд тэрээр энэ дао номполтонг урихаар шийдсэн. Эл урилгыг хүргүүлэхээр 1219 онд тэрээр зар түгээгчээ Лайжоу хот дахь алслагдмал Хаотянь сүм үрүү илгээсэн. Чанчунь урилгыг хүлээн аваад замдаа гарсан. Чингис 1222 оны 4-р сарын 5-нд Чанчуньтай анх удаа уулзах үедээ тавьсан түүний эхний асуултууд нь "мөнхийн амьдрал"-ын тухай байв. Тэрээр асуусан нь: "Хaa нэгтээ алс холын тэртээгээс та нааш ирэхдээ хүний насыг уртасгах ямар анагаагч ургамлыг бидэнд олж ирэв дээ?"<sup>31</sup> Гэвч түүний урмыг хугалахаас өөр арга Чанчуньд байсангүй. Чанчунь хариулсан нь: "Надад амьдралыг хамгаалах шидтэй дао л байна, харин мөнх амьдруулах ямар эм алга байна."<sup>32</sup> Гэсэн хэдий ч тэр номполтны гүн ухаан Чингист маш их сэтгэгдэл төрүүлсэн. Тэрхүү цэцэн ухаантанг хүндэтгэсэн түүний хүндэтгэл нь тэрээр даогийн шашны сүм хийдүүдийг татвараас чөлөөлөх зарлиг гаргаснаар илэрч байна. Тэр эрдэмтэй ламд Чингисээс явуулсан үдэлтийн захианд ч гэсэн түүний энэ хүнийг хүндэтгэх хүндэтгэл бага ч атугай илэрсэн байна. Уг захианд: "Хавар чи надаас салан одсон билээ, харин одоо зун болоод аялан явахад шарагдам халуун, хэцүү байна. Чи замдаа явах унаа уншиндаа өртөө улааны сайн морь аваа юу? Замдаа цадтал сайн идэж, ууж байгаа юу? бага биш биз дээ? Шуньтяньфу түшмэд чамайг сайхан арчилж байна уу? Чи хүмүүсийг опсон уу? Чиний бие чинь сайн байгаа биз дээ? Энд би бурханлиг үхэшгүй мөнх хүн, чиний тухай байнга бодож байна. Би чамайг мартаагүй. Харин чи намайг бас бүү мартаарай!"<sup>33</sup> гэжээ.

<sup>31</sup> Li Zhichang, Xi you, shang 45.

<sup>32</sup> Мөн тэнд.

<sup>33</sup> P. Ratchnevsky, Genghis Khan, His Life and Legacy, Oxford 1991, тал-149-150.